



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/464

Шивээговь сум

Эрүүл мэндийн төвд ор нэмж батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сумын Онцгой комиссын 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 51 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Коронавирус (COVID-19) халдварын дэгдэлт, цар тахлын үед сумын өвчлөл нэмэгдэж, нөхцөл байдал хүндэрсэн тул Эрүүл мэндийн төвийн халдварт өвчний тусгаарлан эмчлэх байранд 21 орыг нэмэлтээр дэлгэж, халдвар хяналтын дэглэмийг баримтлан үйлчлүүлэгчдийг эмчлэн эрүүлжүүлэхийг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Болортайван)-д үүрэг болгосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Ч.Сугармаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ